

**Аэрологийн ажиглалтын голлох элемент, үзэгдэл**

Агаар мандлын дээд давхаргын цаг уурын элемент	Хэмжигдэхүүний нэр	Хэмжлийн нэгж	Боловсруулалт	Тодорхойлолт
		Нэр/ тэмдэглээ		
Даралт	тухайн хугацааны	гектоПаскаль (гПа)	хугацаа, хоног, 10 хоног, сар	Агаар нь атом молекулаас тогтсон нэгэн төрлийн хийн бие учраас тодорхой хэмжээний жинтэй байна. Агаарын энэ жинг агаарын даралт гэнэ. Сонгомол даралтын 850гПа, 700гПа,500гПа, 400гПа, 300гПа, 250гПа,200гПа, 150гПа, 100гПа, 70гПа, 50гПа, 30гПа, 20гПа, 10гПа-н цаг уурын элементийг хэмждэг.
Өндөр	тухайн хугацааны	метр (м)	хугацаа, хоног, 10 хоног, сар	Сонгомол даралтын 850гПа, 700гПа, 500гПа, 400гПа, 300гПа, 250гПа, 200гПа, 150гПа, 100гПа, 70гПа, 50гПа, 30гПа, 20гПа, 10гПа-н гадаргуудын өндрийг хэмждэг.
Агаарын температур	тухайн хугацааны	цельсийн градус (°C)	хугацаа, хоног, 10 хоног, сар	Агаарын температур гэж дулааны төлөв байдлыг илэрхийлэх хэмжигдэхүүн юм.Газрын гадарга, сонгомол даралтын гадаргууд болон температур, чийгийн онцлог цэгийн агаарын температурыг тодорхойлдог.
Харьцангуй чийгшил	тухайн хугацааны	хувь (%)	хугацаа, хоног, 10 хоног, сар	Агаар дахь усны уурын даралтыг тухайн температурт байж болох усны уурын хамгийн их даралтад харьцуулж хувиар илэрхийлснийг харьцангуй чийгшил гэнэ. Газрын гадарга, сонгомол даралтын гадаргууд болон температур, чийгийн онцлог цэгийн агаарын температурыг тодорхойлдог. (газрын гадаргаас дээш агаар мандлын чийгийг хэмжих)

Салхины хурд	дундаж	секунд дэх метр (м/с)	хугацаа, хоног, 10 хоног, сар	Агаарын даралтын зөрөөнөөс үүссэн хэвтээ чиглэлийн урсгал хөдөлгөөнийг салхи гэнэ. Газрын гадарга, сонгомол даралтын гадаргууд болон салхины онцлог цэгийг тодорхойлдог.
Салхины зүг	чиглэл	нумын өнцөг, зовхис/ градус, Ө,ӨЗӨ, ЗӨ...	хугацаа, хоног, 10 хоног, сар	